2021 оны 01 сарын 29-ний өдөр Дугаар А/46 Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталж, уг төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, дүнг танилцуулж ажиллахыг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар /Ц.Уртнасан/-т даалгасугай.

2.Захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг холбогдох хууль, журамд нийцсэнийг үндэслэн санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Н.Наранбаатар/-т зөвшөөрсүгэй.

3.Энэ Захирамжийн хавсралтын 1-4 дэх заалтад тусгагдсан төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар /Б.Мөнхбат/-т, 5 дахь заалтад тусгагдсан төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Мэдээлэл, технологийн газар /О.Чинзориг/-т, 6-11 дэх заалтад тусгагдсан төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Сонгинохайрхан дүүргийн Захиалагчийн алба /Д.Алтанхуяг/-нд, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар /М.Баяраа/-т тус тус даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ Д.СУМЪЯАБАЗАР

Нийслэлийн Засаг даргын 2021 оны
01 дүгээр сарын 29-ний өдрийн
А/46 дугаар захирамжийн хавсралт

НИЙСЛЭЛИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР 2021 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

/сая төг/

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа	Төсөвт өртөг	2021 онд санхүүжих дүн
1	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил /БГД, 1 дүгээр хороо/	2021	100.0	100.0
2	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил /БГД, 2 дугаар хороо/	2021	100.0	100.0
3	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил /БГД, 3 дугаар хороо/	2021	100.0	100.0
4	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил /БГД, 4 дүгээр хороо/	2021	100.0	100.0
5	Шилэн кабелийн сүлжээ, камержуулалтын ажил /НД/	2021	400.0	400.0
6	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил /СХД/	2021	400.0	400.0
7	Гудамжны гэрэлтүүлэг /СХД, 22 дугаар хороо/	2021	90.0	90.0
8	Гудамжны гэрэлтүүлэг /СХД, 33 дугаар хороо/	2021	90.0	90.0
9	Гудамжны гэрэлтүүлэг /СХД, 34 дүгээр хороо/	2021	100.0	100.0
10	Ус түгээх байр /СХД, 22 дугаар хороо/	2021	60.0	60.0
11	Ус түгээх байр /СХД, 35 дугаар хороо/	2021	60.0	60.0
НИЙТ ДҮН			1,600.0	1,600.0